



“ОЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ТӨВ” УТҮГ-
ЫН ЗАХИРАЛ Д.МӨНХБАТ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23. № 3/324
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ-ын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

[Signature]

Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\20170223\SAG23.docx

УХАС.122

07.03.2017



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

“ОЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ТӨВ” УТУГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

САГ-ын дарга, Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер:
Утас: 260512
Цахим хаяг: sambuunyamya@audit.gov.mn

Аудитор: Б.Сэржмядаг
Утас: 260512
Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn

**ТАБ-ын хаяг: 3Г-ын IY байр
Бага тойруу 6 Улаанбаатар -46**

“Мишээл-Од Аудит” ХХК-ийн

Аудитын багийн ахлагч Т.Одончимэг
Утас: 99069029, 96659029

Ахлах аудитор: О.Цэндхүү
Аудиторын туслах: М. Батмагнай
Аудиторын туслах: Э.Энхцэцэг
Утас: 99087892, 99065204

Хаяг: БГД 2 хороо Time center 601, 603

Вэб хуудас: www.misheelodaudit.mn

Имайл хаяг: misheelod@yahoo.com

Аудитын тайлан

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Аудитын тайлан

Хавсралт 3 Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Судалгаа

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Материаллаг байдал
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны талаарх мэдээлэл:
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

НЭГ. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэхь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ/2017/259/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ нь санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төсвийн захирагчийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 02 дугаар сарын 10-ныг хүртэл хийхээр төлөвлөн багийн гишүүн “Мишээл-Од Аудит” ХХК-ийн захирал, аудитын багийн ахлагч Т.Одончимэг удирдан зохион байгуулж аудитор, туслах аудитор 4 ажилтан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. /ТАБ-СТА-А-9/

“Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 01 дүгээр сарын 24-нд “Мишээл-Од Аудит” ХХК-д ирүүлсэн байна. Завсрын үеийн аудитыг 2016 оны 10 дугаар сарын 24-нөөс 11 дүгээр сарын 16-ны хооронд, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас

2017 оны 02 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 15-нд “Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ-ын удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын Ерөнхий хууль, зэрэг хуулиудын болон холбогдох хууль, тогтоол, шийдвэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол улсын Засгийн газрын 2012 оны 89 дугаар тогтоолоор ой хамгаалал, арчилгаа, нөхөн сэргээлт, үржүүлэг, судалгаа, зураг, төсөл, хяналт шинжилгээ хийх үүрэгтэй “Ойн судалгаа, хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрыг байгуулан Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны харъяанд ажиллуулж байна.

“Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ доор дурдсан үндсэн чиглэлүүдээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Мод, сөөгний үрийн дээжид шинжилгээ хийх, ойн шилмэл үрийн нөөц бүрдүүлэх, хадгалах, худалдан борлуулах;
- Монгол оронд ургадаг модлог ургамлын цуглуулгын цэцэрлэгт хүрээлэнгийн /Дендрари/ үйл ажиллагаа эрхлэх;
- Байгаль орчны онлайн мэдээллийн сан дахь ойн мэдээллийн санг мэдээлүүлж, баяжуулах;
- Ойн тооллого, ой зохион байгуулалтын ажлын тайланг нэгтгэн боловсруулах, дүн шинжилгээ хийх, сэдэвчилсэн зураг боловсруулах;
- Ойжуулалтын ажлын зураг төсөл хийх, таримал ойг улсын ойн санд хүлээн авах эсэх талаар дүгнэлт гаргах;
- Хууль бус мод бэлтгэл, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа бусад арга хэмжээг зохион байгуулах, хяналт мониторинг хийх;
- Ойн хөнөөлт шавж, өвчний голомтын судалгаа хийж дүгнэлт гаргах;
- Ойн тооллого, ой зохион байгуулалт, хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт, мониторинг хийх;
- Ой хамгаалал, зүй зохистой ашиглалт, ойн нөхөн сэргээлтийн чиглэлээр шинэ техник, технологийг турших, нутагшуулах;

- Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний норм, стандартыг шинэчлэх чиглэлээр судалгаа хийж, санал боловсруулах;
- Ойн төлөв байдлыг сайжруулахад чиглэсэн ойн аж ахуйн арга хэмжээг зохион байгуулах, мэргэжлийн удирдлага зохицуулалтаар хангаж ажиллах;
- “Ойн тухай” хууль тогтоомжийг сурталчлах, сургалт зохион байгуулах, бүх нийтээр мод тарих арга хэмжээг зохион байгуулах;
- Ойн дагалт баялаг, хушны самар, ойн үрийн ургацын судалгаа хийж дүгнэлт гаргах;
- Аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөний төслийг хянаж дүгнэлт гаргах, улсын ойн менежментийн төлөвлөгөөний төсөл боловсруулах;
- Ойн анги, нөхөрлөл, мэргэжлийн аж ахуйн нэгж, байгууллагад заавар, зөвлөгөө өгч, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;
- Ойгоос мод бэлтгэх талбай тусгаарлах болон ойн арчилгаа, цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах, сургалт, хяналт, мониторинг хийх;
- Хууль тогтоомжоор хориглоогүй, чиг үүрэгт хамаарах бусад үйлдвэрлэл, ажил үйлчилгээ эрхлэх.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол улсын төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу ажиллаж байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “агентлагын дарга тус агентлагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу “Ойн судалгаа хөгжлийн төв” УТҮГ-ын дарга төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэдэг.

“Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ-ын төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж, нэгдүгээр гарын үсгийг Довдонцэрэн овогтой Мөнхбат, хоёрдугаар гарын үсгийг Дорж овогтой Мягмарсүрэн нар зурж төсвийн хөрөнгийг зарцуулж байна.

“Ойн судалгаа хөгжлийн төв” УТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан болно.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн

тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын 12 чиглэлээр 36 уламжлалт сорил, 3 хяналтын сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаатай танилцахад Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох хууль, журам, зааварт нийцүүлэн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, нягтлан бодох бүртгэлийн “Аколоус” програмтай байна. Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Бид “Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ-ын ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Тав. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ-ын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Зургаа. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төлөвлөлтийн үед төсвийн хуваарийн зарлагыг суурь болгон авч 1,156.8 сая төгрөгийн 1.0 %-иар тооцож 11.6 сая төгрөгөөр тооцож, гүйцэтгэлийн үед санхүүжилт өссөн учир материаллагын түвшинг дахин тогтоож 1,778.4 сая төгрөгийн 1.0%-иар тооцож 17.8 сая төгрөгөөр тогтоон аудитын сорилуудыг гүйцэтгэхэд материаллаг хэмжээний зөрчил гараагүй болно.

Долоо. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Тайлант онд урсгал төсөвт 226.1 сая төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 223.9 сая төгрөгийн санхүүжилт авч 206.8 сая төгрөгийг зарцуулж 17.1 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн. Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардалд 1,544.8 сая төгрөг төсөвлөснөөс 1,554.5 сая төгрөгийн санхүүжилт авч 1,541.8 сая төгрөгийг зарцуулж 12.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Тус байгууллага нь үндсэн мэргэжилтэн 12, гэрээт ажилтан 21, нийт 33 хүний бүрэлдэхүүнтэй ажил үүргээ гүйцэтгэж байна.

Найм. Шилэн дансны мэдээлэл

2014 оны 7 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Шилэн дансны тухай хууль батлагдан мөрдөх болсонтой холбогдуулан, хуулийг хэрэгжүүлэх зорилгоор 2015 оноос хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

<http://www.shilendans.gov.mn/> цахим хуудсанд байгууллагаа бүртгүүлэн 801108413@gov.mn хаяг авч, байгууллагын батлагдсан төсвийг зохих маягтын дугуу оруулж, төсвийн гүйцэтгэлийг сар бүр зохих маягтын дагуу байршуулсан байна.

<http://shilendans.gov.mn/> kod-0916 /цахим хуудасны Төсвийн ил тод байдлын тухай гэсэн цэсэнд байгууллагын батлагдсан 2016 оны төсвийг байрлуулаад, төсвийн гүйцэтгэлийн 1-12 сарын мэдээ, харилцах, кассаас зарцуулсан зарцуулалтууд, тендерийн бүх мэдээлэл, худалдан авалтуудыг бүрэн байршуулаад байна.

Үндэсний Аудитын газраас 2016 онд шилэн дансны гүйцэтгэлд хийсэн 1 удаагийн аудитаар зөрчил дутагдал гараагүй, зөвлөмж аваагүй байна.

Ёс. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 12 чиглэлд уламжлалт болон хяналтын эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр уламжлалт 36, нарийвчилсан 5, нийт 41 горим, сорил гүйцэтгэв. Гүйцэтгэсэн сорилын үр дүнгээс харахад тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайланд материаллаг хэмжээний зөрчил илрээгүй бөгөөд үйл ажиллагааны үр дүн сайн байсан гэж бид үзсэн болно.

Арав. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

“Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний бүх ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт ажил гүйлгээг 70,0 орчим хувь хамарсан байна.

Арван нэг. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Завсрын аудитын явцад залруулагдах материаллаг дараах алдаа илэрсэнд аудитын зөвлөмж хүргүүлсэн болно. Үүнд:

1. Эд хариуцагчийн картанд бүртгэлтэй, ашиглаж байгаа, өндөр өртөгтэй 43.9 сая, агуулахад биетээр оршин байгаа 274.7 сая нийт 318.6 сая төгрөгийн бараа материалыг холбогдох шийдвэргүйгээр данснаас хассан нь УСНББОУС-12.44-д “Бараа материалыг борлуулах, солилцох буюу хувиарлах үед тэдгээр бараа материалын дансны үнийг холбогдох орлогыг хүлээн зөвшөөрсөн тайлант үеийн зардал гэж хууль зөвшөөрөх ёстой” гэснийг зөрчин үндэслэлгүйгээр зардалд бичсэн байна. Мөн 27.5 сая төгрөгийн түүхий эд PVC материалыг ашиглан 5 хос 77320 ширхэг бортого үйлдвэрлэсэн ба тэдгээрийг бэлэн бүтээгдэхүүний дансны орлогод аваагүй байгаа нь Сангийн сайдын 294 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, тэдгээрийн эрх, үүрэг, ажилд томилох, чөлөөлөх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар, журам болон УСНББОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөх” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: ЯАГ 2016 оны 12 сарын 28-ны өдөр зөвлөмж хүргүүлж, жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

2. МУ-н заасгийн газрын 2014 оны 30-р тогтоолоор батлагдсан “Ойн цэвэрлэгээ хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх дэвшилтэт техник, тоног төхөөрөмжийг орон нутаг турших, нутагшуулах, суртацилах, танилцуулах, үзүүлэх сургалт зохион байгуулах зорилгоор Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хүрээнд тайлант онд худалдаж авсан 2 ширхэг 292.6 сая төгрөгийн тракторын иж бүрдлийг Төв аймгийн Мөнгөн морьт сумын “Сайхансанаа” ХХК, Сэлэнгэ аймгийн Мандал

сумын “Хангайн бүргэд” ХХК-иудад үнэ төлбөргүй ашиглуулж бараа материалын дансанд бүртгэсэн байна. Энэ нь үндсэн хөрөнгө биетээр оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ҮАГ 2016 оны 12 сарын 28-ны өдөр зөвлөмж хүргүүлж, жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

3. Тайлант онд худалдан авсан 4.8 сая төгрөгийн 1 ширхэг трактор 13.5 сая төгрөгийн 5 ширхэг усалгааны систем нийт 18.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна. Энэ нь “УСНББОУС-17-17-д байгууллага нэг ба түүнээс дээш жил ашиглана гэж тооцож байгаа томоохон эд анги болон нөөцөлж буй тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгө гэж үзнэ. Үүнтэй төстэйгээр хэрэв эд анги нөөцөлж буй тоног төхөөрөмжийг зөвхөн үндсэн хөрөнгөтэй холбоотой ашигладаг бол тэдгээрийг мөн үндсэн хөрөнгө гэж бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь ҮАГ 2016 оны 12 сарын 28-ны өдөр зөвлөмж хүргүүлж, жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Аудитын явцад материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Тус байгууллагад бүртгэлтэй АУ-8000 шүршигч төхөөрөмж 69.5 сая төгрөгийн үнэтэй 2 ком, 98.0 сая төгрөгийн үнэтэй 1 ком бүртгэлтэй байгаа ба эдгээр нь “Хүннү эйр” ХХК-ийн АН-2 онгоцонд зүүлттэйгээр хадгалагдаж, ашиглагдахгүй байна. Гэтэл 2016 онд “Хүннү эйр” ХХК тендерт ялаагүй гэсэн шалтгаанаар хор шүрших ажиллагааг “Гранд форест” ХХК-ийн онгоцоор 139.9 сая төгрөгийн зардал гарган гүйцэтгүүлсэн байна. Улмаар 2017 онд ойн хөнөөлт шавьжтай агаарын хөлөг ашиглан тэмцэх ажилд 1,650.2 сая төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн байгаа ба үүнд уг төхөөрөмжүүдийг ашиглан зардал хэмнэх боломжийг судлаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид ашиглалтгүйгээр бусдын агуулахад хадгалагдаж байгаа 167.5 сая төгрөгийн 3 ком шүршигч төхөөрөмжийг ашиглах боломжийг судлах талаар зөвлөмж өгөх

2. 2016 оны жилийн эцсийн тооллогоор модлог ургамлын цэцэрлэгт 62731 ширхэг мод, бут, сөөг тоологдсон ба эдгээр нь санхүүгийн тайланд тусгагдаагүй байгаа нь УСНББОУС 27.13-д Өнгөрсөн үйл явдлын дүнд байгууллага уг хөрөнгийг хянадаг, Хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн өгөөж эсвэл боломжит үйлчилгээг байгууллага хүртэх магадлалтай ба хөрөнгийн бодит үнэ цэнэ эсвэл

өртгийг найдвартай хэмжиж болох биологийн хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: УСНББОУС 27 –Хөдөө аж ахуй гэсэн стандартыг мөрдөж, 2017 онд Сангийн яамнаас гарах заавар журмыг баримтлан 62731 ширхэг мод, бут, сөөгийг орлогод авч бүртгэх талаар зөвлөмж өгөх

Арван хоёр. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад материаллаг бус залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг баталгаажуулахаар аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний бүх ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгасан ба дараагийн аудитаар 2016 онд өгсөн зөвлөмийн биелэлтийг хянахаас гадна 2017 онд ойжуулалт, ойн арга хэмжээний ажлын зарцуулалтын төсөв 2016 оноос 2.8 дахин нэмэгдэж 4,5 тэрбум төгрөгөөр батлагдсан байгаа учир уг төсвийн зарцуулалтын үр дүн бодитой байгаа эсэхийг үзэх болно.

Арван дөрөв. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын явцад нийт 819,7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 652,2 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 167.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч байна.

Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ-ын 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас итгэл үзүүлсэн тул аудит хийгдээгүй. 2016 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар 652,2 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлж, биелэлтийг “Ойн судалгаа хөгжлийн төв” УТҮГ-ын 2017 он 1/19 тоот албан тоотоор ирүүлснийг тайланд хавсаргасан болно.

Арван зургаа. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Зөрчилгүй санал дүгнэлт

“Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайланг хавсаргав.



“ОЙН СУДАЛГАА ХӨГЖЛИЙН ТӨВ” УТУГ-ЫН 2016 ОНЫ ЗАВСРЫН ҮЕИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

САГ-ын дарга, Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер:
Утас: 260512
Цахим хаяг: sambuunyamyia@audit.gov.mn

Аудитор: Б.Сэржмядаг
Утас: 260512
Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: ЗГ-ын IY байр
Бага тойруу 6 Улаанбаатар -46

“Мишээл-Од Аудит” ХХК-ийн

Аудитын багийн ахлагч Т.Одончим
Утас: 99069029, 96659029

Ахлах аудитор: О.Цэндхүү
Аудиторын туслах: М. Батмагнай
Аудиторын туслах: Э.Энхцэцэг
Утас: 99087892, 99065204

Хаяг: БГД 2 хороо Time center 601, 6С

Вэб хуудас: www.misheelodaudit.mn

Имэйл хаяг: misheelod@yahoo.com

2017 оны 02 дүгээр сарын 11

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол № 1 зүйлс:

Асуудал 1
Хөрөнгийн ашиглалтын талаар 3

Тэргүүлэх ач холбогдол № 2 зүйлс:

Асуудал 2
Хөрөнгийн бүртгэлийн талаар 4



2017 оны 2 дугаар сар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ-ын захиралд зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай компанийн үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ-ын холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллагад АУ-8000 шүршигч төхөөрөмж 69.5 сая төгрөгийн үнэтэй 2 ком, 98.0 сая төгрөгийн үнэтэй 1 ком бүртгэлтэй ба эдгээр нь “Хүннү эйр” ХХК-ийн АН-2 онгоцонд зүүлттэй тэнд хадгалагдаж, ашиглагдахгүй байна. Гэтэл 2016 онд “Хүннү эйр” ХХК тендерт ялаагүй гэсэн шалтгаанаар хор шүрших ажиллагааг “Гранд форест” ХХК-ийн онгоцоор 139.9 сая төгрөгийн зардал гарган гүйцэтгүүлсэн байна. Улмаар 2017 онд ойн хөнөөлт шавьжтай агаарын хөлөг ашиглан тэмцэх ажилд 1,650.2 сая төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөнд уг төхөөрөмжүүдийг ашиглан зардал хэмнэх боломжийг судлаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтыг зөрчиж байна.

ҮАГ-ын зөвлөмжүүд

Цаашид ашиглалтгүйгээр бусдын агуулахад хадгалагдаж байгаа 167.5 сая төгрөгийн 3 ком шүршигч төхөөрөмжийг ашиглах, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахад санаачилгатай ажиллах

Үйлчлүүлэгчийн хариу

Манай байгууллагын эзэмшилд байгаа 167,5 сая төгрөгийн 3 ком шүршигч төхөөрөмжийг үндсэн үйл ажиллагаандаа ашиглах тал дээр анхааран үзэж зардал хэмнэх боломжийг судлан төсвийн хөрөнгийг зүй зохистой ашиглах болно.

Эрсдэлүүд

1. Дүрэм, журам зөрчснөөс хөрөнгө зүй бусаар зарцуулагдах, эзэнгүй болох, /ТБ,Х, Ү, ҮЗ/
2. УСНББОУС-17-г мөрдөж ажиллаагүйгээс хөрөнгө буруу бүртгэгдэх/ ОБ, ЭҮ, Х, ТИ/

ҮАГ-ын ажиглалт

2016 оны жилийн эцсийн тооллогоор модлог ургамлын цэцэрлэгт 62731 ширхэг мод, бут, сөөг тоологдсон ба эдгээр нь санхүүгийн тайланд тусгагдаагүй байгаа нь УСНББОУС 27.13-д Өнгөрсөн үйл явдлын дүнд байгууллага уг хөрөнгийг хянадаг, Хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн өгөөж эсвэл боломжит үйлчилгээг байгууллага хүртэх магадлалтай ба хөрөнгийн бодит үнэ цэнэ эсвэл өртгийг найдвартай хэмжиж болох биологийн хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ гэсэн заалтыг зөрчиж байна.

Эрсдэлүүд

1. Дүрэм, журам зөрчснөөс хөрөнгө зүй бусаар зарцуулагдах, эзэнгүй болох,
/ТБ,Х, Ү, ҮЗ/
2. УСНББОУС-27-г мөрдөж ажиллаагүйгээс хөрөнгө буруу бүртгэгдэх/ ОБ, ЭҮ, Х, ТИ/

ҮАГ-ын зөвлөмж

УСНББОУС 27–Хөдөө аж ахуй гэсэн стандартыг мөрдөж, 2017 онд Сангийн яамнаас гарах заавар журмыг баримтлан 62731 ширхэг мод, бут, сөөгийг орлогод авч бүртгэх

Үйлчлүүлэгчийн хариу

Гадуур бүртгэлтэй байгаа 62731 ширхэг бут сөөгийг Сангийн яамны мэргэжилтэн болох Даариймаатай ярилцан бүртгэлийн журам гаргаж 2017 онд бүртгэж авахаар тохиролцсон.

"ОИН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ТӨВ" УТУГ-ЫН АУДИТ ХИИГДСЭН
2016 ҮЙС АЖИЛЛАХ ҮНДЭМ
НАЙЗСАН АЖИЛЛАХ ҮНДЭМ

(төгрөгөөр)

Хэрэгжүүлэгдэх	Аудитаар баталгаажсан үлдэгдэл	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	0.00	(0.00)
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	0.00	(0.00)
АВЛАГА	8,731,475.78	360,000.00
Бусад авлага	8,731,475.78	360,000.00
БАРАА МАТЕРИАЛ	769,763,943.15	725,789,634.71
Түүхий эд материал	59,587,213.11	42,546,313.10
Бэлэн бүтээгдэхүүн	-	26,063,798.80
Хангамжийн материал	710,176,730.04	657,179,522.81
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	778,495,418.93	726,149,634.71
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	869,431,994.85	801,649,854.99
Биет хөрөнгө	869,431,994.85	801,649,854.99
Барилга, байгууламж	257,733,446.40	257,733,446.40
Хуримтлагдсан элэгдэл	(148,893,565.27)	(154,466,171.59)
Авто тээврийн хэрэгсэл	497,205,481.38	497,205,481.38
Хуримтлагдсан элэгдэл	(185,262,883.25)	(242,552,663.57)
Машин, тоног төхөөрөмж	940,346,323.13	1,116,375,693.13
Хуримтлагдсан элэгдэл	(515,648,448.38)	(691,190,701.60)
Тавилга, аж ахуйн эд хогшил	72,263,594.18	72,263,594.18
Хуримтлагдсан элэгдэл	(50,902,473.63)	(54,393,823.34)
Бусад үндсэн хөрөнгө	32,813,449.80	32,813,449.80
Хуримтлагдсан элэгдэл	(30,222,929.51)	(32,138,449.80)
Програм хангамж	600,000.00	600,000.00
Хасагдуулга	(600,000.00)	(600,000.00)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	869,431,994.85	801,649,854.99
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,647,927,413.78	1,527,799,489.70
Богино хугацаат өр төлбөр	(0.00)	58,815.00
Өглөг	(0.00)	58,815.00
Ажиллагчидтай холбогдсон өглөг	(0.00)	58,815.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	(0.00)	58,815.00
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	(0.00)	58,815.00
Засгийн газрын оруулсан капитал	536,870,268.14	536,870,268.14
Өмнөх үеийн үр дүн	1,111,057,145.64	1,111,057,145.64
Тайлант үеийн үр дүн	-	(120,186,739.08)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,647,927,413.78	1,527,740,674.70
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,647,927,413.78	1,527,799,489.70

"ОЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ТӨВ" УТУГ-ЫН АУДИТ ХИЙГДСЭН
2016 Í Í Ò ÆËËËÍ ÝÕÑËÍ
ÑÀÍ Õ ÆËÍ Ò Æ Í ÆËÍ ÕÀËËÁ

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

(төгрөгөөр)

ᠮᠤᠰᠤᠯᠠᠮᠵᠡ	Аудитаар баталгаажсан дүн	
	Өмнөх он	Тайлант он
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	-
Урсгал	228,383,700.00	223,973,485.00
Улсын төсвөөс	1,507,345,352.10	1,768,734,356.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	1,278,961,652.10	1,544,760,871.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	-	41,448,000.00
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	54,408,570.00	-
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	1,224,183,528.00	1,503,312,871.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	369,554.10	-
Бараа, үйлчилгээний орлого	339,129,910.78	9,760,000.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	30,207,218.94	9,760,000.00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	339,129,910.78	9,760,000.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	308,922,691.84	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,846,475,262.88	1,778,494,356.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,647,785,391.20	1,866,245,171.81
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	283,682,416.88	296,708,834.29
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	255,423,884.89	266,919,366.64
Цалин	147,593,447.84	251,489,366.64
Унаа хоолны хөнгөлөлт	23,112,000.00	15,430,000.00
Гэрээтийн цалин	84,718,437.05	-
Нийгмийн хамгааллын шимтгэл	28,258,531.99	29,789,467.65
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	23,178,460.85	26,864,848.94
Тэтгэврийн даатгалын шимтгэл	18,040,951.94	23,898,103.94
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,061,823.08	438,411.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,567,678.72	1,483,372.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	508,007.11	1,044,962.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,080,071.14	2,924,618.71
Тогтмол зардал	11,889,607.00	9,644,428.00
Гэрэл цахилгааны зардал	1,270,320.00	2,488,482.40
Түлш, халаалтын зардал	7,550,500.00	5,275,945.60
Цэвэр, бохир усны зардал	-	705,000.00
Байрны түрээс	3,068,787.00	1,175,000.00
Хангамж, бараа материалын зардал	53,546,530.18	44,450,215.52
Бичиг хэргийн материал	11,934,830.00	10,622,891.88
Тээвэр, шатахууны зардал	14,554,500.00	19,460,300.00
Шуудан холбоо интернетийн төлбөр	11,255,399.00	9,388,423.64
Ном, хэвлэлийн зардал	13,459,200.00	320,000.00
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	2,342,601.18	4,658,600.00
Нормативт зардал	14,868,800.00	2,110,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,868,800.00	2,110,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	22,047,800.00	4,528,110.00
Багаж хэрэгсэл	1,280,100.00	-
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	2,675,000.00	484,800.00
Урсгал засвар	18,092,700.00	4,043,310.00
Томилолт, зочны зардал	133,506,755.00	157,621,828.00
Дотоод томилолтын зардал	133,506,755.00	157,621,828.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	555,183,376.00	654,919,270.98

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	554,424,676.00	646,214,018.98
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	3,000,000.00
Даатгалын үйлчилгээний төлбөр	-	4,963,752.00
Тээврийн хэрэгслийн татвар	632,200.00	637,000.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	126,500.00	104,500.00
Бараа үйлчилгээний бусад зардал	573,060,106.14	696,262,485.02
Бусад зардал	326,444,431.40	422,140,975.16
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	39,652,926.00	30,310,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	206,962,748.74	243,811,509.86
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,720,070.21	32,435,923.27
Засгийн газрын урсгал шилжүүлэг	23,062,077.21	29,867,538.27
төвлөрүүлэх шилжүүлэг	23,062,077.21	29,867,538.27
Бусад урсгал шилжүүлэг	55,657,993.00	2,568,385.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	53,689,993.00	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	2,568,385.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,968,000.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,726,505,461.41	1,898,681,095.08
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	119,969,801.47	(120,186,739.08)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	-
Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	676,411.77	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	676,411.77	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	-
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	451,841,400.84	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	451,841,400.84	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(331,195,187.60)	(120,186,739.08)

"ОЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ТӨВ" УТУГ-ЫН АУДИТ ХИЙГДСЭН
2016 Î Í Ò ÆËËËËÍ ÝÕÑËËÍ
ᠠᠶᠢᠬᠡᠭᠡᠢ ᠠᠶᠢᠨ ᠳᠤᠬᠤᠭᠡᠢ ᠡᠭᠡᠢᠨ ᠠᠶᠢᠨ

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2014 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	536,870,268.14	0.00	1,442,252,333.24	0.00	1,979,122,601.38
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	536,870,268.14	0.00	1,442,252,333.24	0.00	1,979,122,601.38
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-331,195,187.60	0.00	-331,195,187.60
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	536,870,268.14	0.00	1,111,057,145.64	0.00	1,647,927,413.78
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	536,870,268.14	0.00	1,111,057,145.64	0.00	1,647,927,413.78
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-120,186,739.08	0.00	-120,186,739.08
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	536,870,268.14	0.00	990,870,406.56	0.00	1,527,740,674.70

**"ОЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ТӨВ" УТУГ-ЫН АУДИТ ХИЙГДСЭН
2016 Í Í Ò ÆËËËËÍ ÝÕÑËËÍ
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Аудитаар баталгаажсан дүн	
	Өмнөх он	Тайлант он
Тусламж, санхүүжилтын орлого	1,450,130,253.10	1,768,734,356.00
Улсын төсвөөс	228,383,700.00	223,973,485.00
Урсгал	228,383,700.00	223,973,485.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	1,221,746,553.10	1,544,760,871.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	-	41,448,000.00
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	54,408,570.00	-
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	1,166,968,429.00	1,503,312,871.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	369,554.10	-
Бараа, үйлчилгээний орлого	54,403,831.65	9,760,000.00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	54,403,831.65	9,760,000.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	54,403,831.65	9,760,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,504,534,084.75	1,778,494,356.00
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,427,086,952.37	1,583,521,312.73
Ажиллагчидтай холбогдсон зардал	283,050,105.37	301,211,065.09
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	255,268,239.95	271,763,248.00
Цалин	135,553,300.00	240,921,885.00
Унаа хоолны хөнгөлөлт	30,748,835.86	30,841,363.00
Гэрээтийн цалин	88,966,104.09	-
Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	27,781,865.42	29,447,817.09
Тэтгэврийн даатгалын шимтгэл	18,497,811.77	19,884,023.09
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,923,453.47	1,995,383.77
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,143,030.98	2,365,126.67
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	474,324.76	473,025.54
Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,743,244.44	4,730,258.02
Бараа үйлчилгээний урсгал зардал	1,144,036,847.00	1,282,310,247.64
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	9,939,107.00	10,359,638.00
Гэрэл цахилгааны зардал	1,270,320.00	2,792,350.00
Түлш, халаалтын зардал	5,600,000.00	5,687,288.00
Цэвэр, бохир усны зардал	-	705,000.00
Байрны түрээс	3,068,787.00	1,175,000.00
Хангамж, бараа материалын зардал	52,071,899.00	38,442,308.64
Бичиг хэрэг	9,332,000.00	9,134,785.00
Тээвэр, шатахуун	13,301,900.00	11,782,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,407,299.00	10,118,323.64
Ном, хэвлэл	13,300,000.00	509,500.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,730,700.00	6,897,700.00
Нормативт зардал	12,071,800.00	7,364,130.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,071,800.00	7,364,130.00
Эд хогшил, урсгал засварын зардал	15,394,140.00	30,711,612.00
Багаж техник хэрэгсэл	7,694,140.00	15,849,902.00
Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	1,600,000.00	1,770,200.00
Урсгал засвар	6,100,000.00	13,091,510.00
Томилолт, зочны зардал	136,897,955.00	160,791,354.00

Дотоод албан томилолт	136,897,955.00	160,791,354.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	851,447,376.00	994,086,445.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	850,688,676.00	985,381,193.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	3,000,000.00
Даатгалын үйлчилгээ	-	4,963,752.00
Тээврийн хэрэгслийн татвар	632,200.00	637,000.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	126,500.00	104,500.00
Бараа үйлчилгээний бусад зардал	66,214,570.00	40,554,760.00
Бараа үйлчилгээний бусад зардал	23,841,600.00	10,244,760.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	42,372,970.00	30,310,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,720,070.21	32,435,923.27
Засгийн газрын урсгал шилжүүлэг	23,062,077.21	29,867,538.27
төвлөрүүлэх шилжүүлэг	23,062,077.21	29,867,538.27
Бусад урсгал шилжүүлэг	55,657,993.00	2,568,385.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	53,689,993.00	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	2,568,385.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,968,000.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	1,505,807,022.58	1,615,957,236.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(1,272,937.83)	162,537,120.00
Хөрөнгийн орлого	-	-
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	76,052,520.00	162,537,120.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	76,052,520.00	162,537,120.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	76,052,520.00	162,537,120.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(76,052,520.00)	(162,537,120.00)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(77,325,457.83)	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.01	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.01	(0.00)

"ОЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ТӨВ" УТУГ-ЫН АУДИТ ХИЙГДСЭН
2016 1 0 ӨӨӨӨӨӨ ҮӨНӨӨӨ
Ор НАӨӨӨ А'ӨӨӨӨӨӨӨӨӨӨ ӨАӨӨӨ

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Аудитаар баталгаажсан үлдэгдэл			
	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	С' дбб	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	226,128,100.00	223,973,485.00	2,154,615.00	99.05
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	226,128,100.00	223,973,485.00	2,154,615.00	99.05
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	226,128,100.00	223,973,485.00	2,154,615.00	99.05
Бараа, үйлчилгээний зардал	222,905,100.00	204,253,912.95	18,651,187.05	91.63
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	162,771,000.00	156,451,971.00	6,319,029.00	96.12
Үндсэн цалин	148,478,100.00	144,416,465.00	4,061,635.00	97.26
Унаа, болон бусад нөхөн олговор	14,292,900.00	12,035,506.00	2,257,394.00	84.21
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,904,700.00	16,796,590.00	1,108,110.00	93.81
Тэтгэврийн даатгал	11,394,104.00	10,951,637.66	442,466.34	96.12
Тэтгэмжийн даатгал	1,302,038.00	1,251,615.77	50,422.23	96.13
ҮОМШӨ ний даатгал	1,627,949.00	1,435,417.67	192,531.33	88.17
Ажилгүйдлийн даатгал	325,611.00	287,083.54	38,527.46	88.17
Байгууллага төлөх ЭМД ийн хураамж	3,254,998.00	2,870,835.36	384,162.64	88.20
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,059,900.00	-	9,059,900.00	-
Гэрэл цахилгаан	4,493,500.00	-	4,493,500.00	-
Түлш, халаалт	4,566,400.00	-	4,566,400.00	-
Хангамж, бараа материалын зардал	20,059,700.00	19,454,921.95	604,778.05	96.99
Бичиг хэрэг	5,897,100.00	5,896,385.00	715.00	99.99
Тээвэр (шатахуун)	7,648,500.00	7,648,500.00	-	100.00
Шуудан холбоо	4,916,600.00	4,315,236.95	601,363.05	87.77
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,597,500.00	1,594,800.00	2,700.00	99.83
Нормативт зардал	2,880,000.00	2,879,130.00	870.00	99.97
Нормын хувцас зөөлөн эдлэл	2,880,000.00	2,879,130.00	870.00	99.97
Эд хогшил худалдан авах	1,574,200.00	1,574,200.00	-	100.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,574,200.00	1,574,200.00	-	100.00
Томилолт, зочны зардал	2,555,600.00	2,555,600.00	-	100.00
Дотоод албан томилолт	2,555,600.00	2,555,600.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	4,600,000.00	4,541,500.00	58,500.00	98.73
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
Даатгалын үйлчилгээ	800,000.00	800,000.00	-	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	640,000.00	637,000.00	3,000.00	99.53
Тээврийн хэрэгслийн оношилгоо	160,000.00	104,500.00	55,500.00	65.31
Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	-	1,500,000.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	-	1,500,000.00	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,223,000.00	19,719,572.05	(16,496,572.05)	611.84
Засгийн газар хоорондын шилжүүлэг	-	17,151,187.05	(17,151,187.05)	-
төвлөрүүлэх шилжүүлэг	-	17,151,187.05	(17,151,187.05)	-
Бусад урсгал шилжүүлэг	3,223,000.00	2,568,385.00	654,615.00	79.69
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3,223,000.00	2,568,385.00	654,615.00	79.69
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	226,128,100.00	223,973,485.00	2,154,615.00	99.05
Төсвөөс санхүүжих	226,128,100.00	223,973,485.00	2,154,615.00	99.05
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
АЖИЛЛАГСАД БҮГД	12.00	12.00	-	100.00
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-	100.00
СУРАЛЦАГСАД /жилийн дунджаар/	-	-	-	-
Ерөнхий боловсролын сургуульд суралцагсад	-	-	-	-

ᠣᠠ ᠨᠠᠡᠡᠢ ᠠᠨᠢᠶᠣᠨᠠᠶᠢᠨᠢ ᠣᠠᠡᠡᠠᠢ /ОЙЖУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ/

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Аудитаар баталгаажсан үлдэгдэл			
	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	᠙° ᠔᠐᠐	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,544,760,871.00	1,554,520,871.01	(9,760,000.01)	100.63
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,544,760,871.00	1,554,520,871.01	(9,760,000.01)	100.63
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,544,760,871.00	1,554,520,871.01	(9,760,000.01)	100.63
Бараа, үйлчилгээний зардал	1,544,760,871.00	1,541,804,519.79	2,956,351.21	99.81
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	116,015,879.00	115,311,277.00	704,602.00	99.39
Үндсэн цалин	96,506,420.00	96,505,420.00	1,000.00	100.00
Унаа, болон бусад нөхөн олговор	19,509,459.00	18,805,857.00	703,602.00	96.39
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,764,104.68	12,651,227.10	112,877.58	99.12
Тэтгэврийн даатгал	9,045,263.00	8,932,385.42	112,877.58	98.75
Тэтгэмжийн даатгал	743,768.00	743,768.00	-	100.00
ҮОМШӨ ний даатгал	929,709.00	929,709.00	-	100.00
Ажилгүйдлийн даатгал	185,942.00	185,942.00	-	100.00
Байгууллага төлөх ЭМД ийн хураамж	1,859,422.68	1,859,422.68	-	100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,464,638.00	10,359,638.00	105,000.00	99.00
Гэрэл цахилгаан	2,792,350.00	2,792,350.00	-	100.00
Түлш, халаалт	5,687,288.00	5,687,288.00	-	100.00
Цэвэр, бохир ус	810,000.00	705,000.00	105,000.00	87.04
Байрны түрээс	1,175,000.00	1,175,000.00	-	100.00
Хангамж, бараа материалын зардал	19,107,302.00	18,987,386.69	119,915.31	99.37
Бичиг хэрэг	3,238,514.00	3,238,400.00	114.00	100.00
Тээвэр (шатахуун)	4,133,500.00	4,133,500.00	-	100.00
Шуудан холбоо	5,857,196.00	5,803,086.69	54,109.31	99.08
Ном хэвлэл авах	510,000.00	509,500.00	500.00	99.90
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	5,368,092.00	5,302,900.00	65,192.00	98.79
Нормативт зардал	4,485,000.00	4,485,000.00	-	100.00
Нормын хувцас зөөлөн эдлэл	4,485,000.00	4,485,000.00	-	100.00
Эд хогшил худалдан авах	47,214,298.32	45,374,532.00	1,839,766.32	96.10
Багаж, техник, хэрэгсэл	33,916,512.00	32,087,022.00	1,829,490.00	94.61
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	196,500.00	196,000.00	500.00	99.75
Урсгал засвар	13,101,286.32	13,091,510.00	9,776.32	99.93
Томилолт, зочны зардал	158,235,754.00	158,235,754.00	-	100.00
Дотоод албан томилолт	158,235,754.00	158,235,754.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,135,864,945.00	1,135,844,945.00	20,000.00	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,131,701,193.00	1,131,681,193.00	20,000.00	100.00
Даатгалын үйлчилгээ	4,163,752.00	4,163,752.00	-	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	40,608,950.00	40,554,760.00	54,190.00	99.87
Бараа үйлчилгээний бусад зардал	10,298,950.00	10,244,760.00	54,190.00	99.47
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,310,000.00	30,310,000.00	-	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	12,716,351.22	(12,716,351.22)	-
Засгийн газар хоорондын шилжүүлэг	-	12,716,351.22	(12,716,351.22)	-
төвлөрүүлэх шилжүүлэг	-	12,716,351.22	(12,716,351.22)	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,544,760,871.00	1,554,520,871.00	(9,760,000.00)	100.63
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	9,760,000.00	(9,760,000.00)	-
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	41,448,000.00	41,448,000.00	-	100.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,503,312,871.00	1,503,312,871.00	-	100.00
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
АЖИЛЛАГСАД БҮГД	12.00	12.00	-	100.00
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-	100.00